

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/01/СТА-ОНӨААН

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Чойр хот 2022 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543156 Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 70543179 Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Анхтуяа Утас: 70543179 Цахим хаяг: ankhtuyab@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	10
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	10
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
5.1 Шилэн дансны мэдээлэл	13
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
8. Аудитын илрүүлэлт	14
8.1 Залруулсан алдаа	14
8.2 Төлбөрийн акт	15
8.3 Албан шаардлага	15
8.4 Зөвлөмж	16
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	0

Товчилсон үгийн жагсаалт

АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт

1.Аудитын санал дүгнэлт

АЙМГИЙН “ТОХИЖИЛТ
СҮМБЭР” ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ц.ЭНХЖАРГАЛ ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Говьсүмбэр аймгийн Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Говьсүмбэр аймгийн Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ -ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	6,352,957,700.45	9,097,229,336.68
1.1	Эргэлтийн хөрөнгө	154,827,427.48	147,149,212.96
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	71,127,460.13	37,942,886.95
1.1.2	Дансны авлага	4,062,891.00	101,171.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	47,081.40	27,644.13
1.1.4	Бусад авлага	23,323,659.95	18,117,045.88
1.1.6	Бараа материал	56,266,335.00	90,960,465.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	154,827,427.48	147,149,212.96
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	6,198,130,272.97	8,950,080,123.72
1.2.1	Үндсэн хөрөнгө	6,081,134,065.20	8,832,680,125.23
1.2.2	Биет бус хөрөнгө	116,996,207.77	117,399,998.49
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,198,130,272.97	8,950,080,123.72
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,352,957,700.45	9,097,229,336.68
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр	802,411.01	116,279.01
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	802,411.01	116,279.01
2.1.1.1	Дансны өглөг	43,879.00	43,879.00
2.1.1.3	Татварын өр	758,532.01	72,400.01
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	802,411.01	116,279.01
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	2,009,914,885.66	5,506,677,061.81
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	2,009,914,885.66	5,506,677,061.81
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,009,914,885.66	5,506,677,061.81
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,010,717,296.67	5,506,793,340.82
2.3	Эздийн өмч	4,342,240,403.78	3,590,435,995.86
2.3.1	Өмч:-төрийн	2,202,002,208.14	2,202,002,208.14
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	6,805,330.88	6,805,330.88
2.3.9	Хуримтлагдсан ашиг	2,133,432,864.76	1,381,628,456.84
2.3.11	Эздийн өмчийн дүн	4,342,240,403.78	3,590,435,995.86
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	6,352,957,700.45	9,097,229,336.68

2.2 Аудит хийсэн орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	82,479,837.00	69,270,532.00
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг(алдагдал)	82,479,837.00	69,270,532.00
8	Бусад орлого	461,153,352.90	501,297,411.00
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	990,752,672.18	1,213,706,722.73
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	44,550,478.74	55,465,992.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/		-48,708,322.12
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-491,669,961.02	-747,313,093.85
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-491,669,961.02	-747,313,093.85
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-491,669,961.02	-747,313,093.85
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	82,479,837.00	570,567,943.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн өн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,202,002,208.14		6,805,330.88		3,531,624,094.14	5,740,431,633.16
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
Залруулсан үлдэгдэл	2,202,002,208.14		6,805,330.88		3,531,624,094.14	5,740,431,633.16
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					-1,398,191,229.38	-1,398,191,229.38
Өмчид гарсан өөрчлөлт						
Зарласан ногдол ашиг						
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,202,002,208.14		6,805,330.88		2,133,432,864.76	4,342,240,403.78
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-4,491,314.07	-4,491,314.07
Залруулсан үлдэгдэл	2,202,002,208.14		6,805,330.88		2,128,941,550.69	4,337,749,089.71
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					-747,313,093.85	-747,313,093.85
Зарласан ногдол ашиг						
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,202,002,208.14		6,805,330.88		1,381,628,456.84	3,590,435,995.86

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйлчилгээний мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	568,840,468.90	579,996,549.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	12,550,350.00	39,862,800.00
	Татаас, санхүүжилтийн орлого	460,783,600.00	512,210,715.00
	Бусад мөнгөн орлого	95,506,518.90	27,923,034.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	536,131,884.23	607,011,222.18
	Ажиллагчдад төлсөн	204,902,229.00	197,154,005.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	63,420,751.54	64,627,582.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	161,771,008.70	212,765,282.7
	Ашиглалтын зардалд төлсөн	27,881,159.26	36,672,677.48
	Татварын байгууллагад төлсөн	14,800,766.99	17,550,873.00
	Бусад мөнгөн зарлага	52,405,968.74	78,240,802.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	43,658,584.67	-27,014,673.18
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,950,000.00	6,169,900.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	8,400,000.00	6,169,900.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,550,000.00	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(10,950,000.00)	(6,169,900.00)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	32,708,584.67	-33,184,573.18
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	38,418,875.46	71,127,460.13
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	71,127,460.13	37,942,886.95

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад зөвлөмж өгөөгүй болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Анхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан, тодруулгыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 32 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус байгууллагын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүү, хяналт аудитын албанаас дотоод аудит, хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 1,035,303.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 10,353.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 7,247.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын зорилго нь “Орон нутгийг хоггүй эрүүл орчинд тав тухтай амьдруулах нөхцөлийг бүрдүүлэх”-д оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбайд хогийн болон дахиврын сав байршуулах, хог хаягдлыг цэвэрлэх, ачиж тээвэрлэх
- Сумын төвийн айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжүүд болон бусад харилцагчдын хог хаягдлыг тогтоосон хугацаанд ачиж тээвэрлэх
- Сумын төвийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн үйл ажиллагааг хариуцах
- Сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийг арчлах, засварлах
- Сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбайн хөшөө, дурсгал, чимэглэлийг арчлах
- Сумын төвийн авто болон явган хүний замын цэвэрлэгээ, арчилгаа
- Нийтийн эзэмшлийн зам талбайн тэмдэг, тэмдэглэгээ, сандал, хогийн сав, явган хайсны ашиглалт засварыг хариуцах
- Хариуцсан машин механизм, техник, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ хийх
- Үйлдвэрийн газар нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг холбогдох эрх бүхий байгууллагын зохих зөвшөөрлөөр эрхлэх

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ыг Сүмбэр сумын Засаг даргын 2002 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 41 дүгээр захирамжийг үндэслэн байгуулсан байна.

Компанийн удирдлагыг Сүмбэр сумын Засаг даргын захирамжаар томилсон ба ТУЗ байгуулаагүй байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж заасан байна. Энэ хүрээнд арга хэмжээ аваагүй байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3-т “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдөөгүй, орон тоог бууруулаагүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	71,127.5	37,942.9	33,184.6
БХХО	0.0	0.0	0.0
Авлага	27,433.6	18,245.9	-9,187.7
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	56,266.3	90,960.5	34,694.2
Үндсэн хөрөнгө	6,081,134.1	8,832,680.1	2,751,546.0
Биет бус хөрөнгө	116,996.2	117,399.9	403.7
Нийт хөрөнгийн дүн	6,352,957.7	9,097,229.3	2,744,271.6
Өр төлбөрийн дүн	2,010,717.3	5,506,793.3	3,496,076.0
Богино хугацаат өглөг	802.4	116.3	-686.1
Урт хугацаат өглөг	2,009,914.9	5,506,677.1	3,496,762.2
Эздийн өмч	4,342,240.4	3,590,435.9	-751,804.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,352,957.7	9,097,229.3	2,744,271.6

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 37,942.9 мянган төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд хог хаягдлын авлага 18,117.0 мянга, бусад авлага 101.2 мянга, НДШ-ийн авлага 27.6 мянган төгрөгийг эзэлж байна.

Авлагын үлдэгдэлд ААНБ, айл өрхөөс авах хугацаа хэтэрсэн 18,117.0 мянган төгрөгийн хог хаягдлын авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 90,960.5 мянган төгрөг болж 34,694.2 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авалт болон үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоос шалтгаалжээ.

Тайлант онд худалдан авалтаар 193,191.0 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 23,432.6 мянга, нийт 216,623.6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Худалдан авсан 6,169.9 мянга, аймгийн ОНХС, ОНХО, УТХО-аар үнэ төлбөргүй нийлүүлэгдсэн 3,736,961.4 мянга, нийт 3,751,114.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, 136,810.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас баланст шилжүүлсэн, 324,672.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, нийт 461,482.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хасагдсан байна.

Үндсэн хөрөнгөөс аймгийн ИТХ-ын 2021 оны 40, 41, 42, 50, 52 дугаар тогтоолоор нийт 324,672.1 мянган төгрөгийн өртөгтэй, 317,537.8 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 18 ширхэг хөрөнгийг акталж, 136,810.7 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 95,236.7 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, нийт 9 ширхэг хөрөнгийг балансаас баланст шилжүүлжээ.

Биет бус хөрөнгө 403.7 мянган төгрөгөөр өссөн нь сумын ОНХС-гаар хийгдсэн усан санд суурилуулсан ухаалаг системийг үнэлж бүртгэснээс шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 116.3 мянган төгрөгийн өр төлбөр байна. Урт хугацаат өр төлбөр дансанд 5,506,677.1 мянган төгрөгийн өр төлбөр байна. Урт хугацаат өр төлбөрийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэхгүй байгаа нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоос үүссэн хойшлогдсон татварын өглөг бүртгэснээс шалтгаалсан байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Тохижилт сүмбэр” ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“Тохижилт сүмбэр” ОНӨААТҮГ нь эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулаагүй байна.

Орлогын дэлгэрэнгүй тайланд 570,567.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,317,881.0 мянган төгрөгийн зардал гарган, 747,313.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Орлогын эх үүсвэр нь орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 418,863.8 мянга, авто замын сангийн санхүүжилт 74,167.6 мянга, сумын ОНХС-гаас 8,266.0 мянга, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 69,270.5 мянган төгрөгийн орлогоос тус тус бүрджээ.

Хүснэгт 2. 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/мян төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		

1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт	/мян төгрөг/					
2	Нийт орлого	мян төгрөг		87,000.0	120,297.4	33,297.4	
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян төгрөг					
3	Нийт зардал	мян төгрөг		-	1,317,881.0	-	
	Үүнээс: а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	мян төгрөг	-	-	-	-	
	б) Ерөнхий ба удирдлагын зардал	мян төгрөг		-	1,213,706.7	-	
	в) Хөрөнгө оруулалт их засвар	мян төгрөг		-	-	-	
4	Цэвэр ашиг, алдагдал	мян төгрөг		*	-747,313.1	-	

Тайлант онд Сүмбэр сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 07 дугаар тогтоолоор хог хаягдлын орлогын төлөвлөгөөг 87,000.0 мянган төгрөгөөр баталсан байна. Гүйцэтгэлээр 120,297.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орлогын төлөвлөгөөг 138.3 хувиар давуулан биелүүлсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,317,881.0 мянган төгрөг болсон ба зардлыг төлөвлөөгүй байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөг гаргаж, батлуулаагүй байна.

Тайлант онд цэвэр алдагдал 747,313.1 мянган төгрөг болсон ба цэвэр ашиг, алдагдлыг төлөвлөөгүй байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ нь тайлант онд нийт 757,360.4 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 192,945.3 мянган төгрөгийн 16 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна. Зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өглөө.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, ТБОНӨХБАҮХАТ хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 26,542.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 26,542.3 мянган төгрөгийг залруулж, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 63,037.3 мянган төгрөгийн 11 алдаа зөрчил, илэрснээс, 48,226.7 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 13,718.9 мянган төгрөгийн 3 зөрчилд 2 төлбөрийн акт, 1,035.6 мянган төгрөгийн 2 зөрчилд зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 56.0 мянган төгрөгийн 1 зөрчилд 1 зөвлөмж өгсөн бөгөөд төлбөрийн акт, албан шаардлага бүрэн хэрэгжсэн, зөвлөмжийн хэрэгжилт 66.6%-тай байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	13,718.9	2	13,718.9	-	-	-
Албан шаардлага	2	1,035.6	2	1,035.6	-	-	-
Зөвлөмж	3	56.0	2	56.0	1	0.0	66.6
Нийт дүн	7	14,810.5	6	14,810.5	1	0.0	66.6

Өмнөх онд хог хаягдлын авлагыг бууруулах талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Иймд алдаа, зөрчил давтан гарсан асуудалд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 240,910.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 26,542.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,306.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 211,062.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлсэн байна.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 26,542.3 мянган төгрөгийн 3 алдааг залрууллаа. Үүнд:

8.1.1 Завсрын аудитаар хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын төлөвлөгөөг 26,542.3 мянган төгрөгийг биелүүлж ажиллаагүй байсныг зөвлөмж өгч залруулсан.

8.1.2 Завсрын аудитаар санхүүгийн тайлангийн тодруулга тайланд авлага, өглөг, бараа материалын тайланг нэр төрлөөр нь задлаагүй байсныг зөвлөмж өгч залруулсан.

8.1.3 Завсрын аудитаар үндсэн хөрөнгийн тайланг данс тус бүрээр бэлтгээгүй байсныг зөвлөмж өгч залруулсан.

8.2 Төлбөрийн акт

8.2.1. Ээлжийн амралтын олговрыг цалин хөлстэй давхардуулан 5 хүнд илүү тооцож олгосон 403.8 мянга, 1 хүнд дутуу тооцож олгосон 58.1 мянга, 5 албан хаагчдад дотоод журмын дагуу тэтгэмж, тусламж олгохдоо 155.0 мянган төгрөгийн ХХОАТ суутгаагүй нийт 616.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5, 20.2.7, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалаар батлагдсан “Ээлжийн амралт олгох заавар”-ын 1 дүгээр хавсралтын 1, 22 дугаар зүйлийн 22.1.1, Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дугаар тушаалын хавсралтын 2.2 дахь заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3, 4.2.3.5-т заасны дагуу төлбөрийн акт хүргүүлэхээр шийдвэрлэв.

8.2.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчиж 17 ажилтанд 2,689.3 мянган төгрөгийн шагнал урамшуулал олгосон зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3 дахь заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.5, 4.2.3.8, УАГ-ын 2022 оны 01/59 дугаар чиглэл хүргүүлсэн албан бичигт заасны дагуу төлбөрийн акт хүргүүлэхээр шийдвэрлэв.

8.3 Албан шаардлага

8.3.1 Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5-н сая төгрөгөөс дээш 13 худалдан авалт, 3 хөрөнгө зарцуулахтай холбоотой тушаал шийдвэр мэдээлээгүй зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.8, 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.2.5, 2.2.3.2, 3 дугаар зүйлийн 3.1.7, 3.2.9 дахь заалтуудыг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

8.3.2 Өмнөх онд барагдуулаагүй үлдсэн ААНБ, айл өрхөөс авах 18,117.0 мянган төгрөгийн хог хаягдлын авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулаагүй, өмнөх онд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтуудыг зөрчсөн, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.10-т заасны дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

8.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй байна.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг хугацаанд нь гаргаж, төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		/мянган төгрөгөөр/								
							Залруулга		Акт		Үүнээс Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Санхүүгийн тайлангийн асуудлаар															
1	“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ	ГСА-2022/01/СТА-ОНӨААН	Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй		1	26,542.3	1	26,542.3							
2	“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ	ГСА-2022/01/СТА-ОНӨААН	Санхүүгийн тайлангийн тодруулга тайланд авлага, өглөг, бараа материалын тайланг нэр төрлөөр нь задлаагүй		1		1	0.0							
3	“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ	ГСА-2022/01/СТА-ОНӨААН	Үндсэн хөрөнгийн тайланг данс тус бүрээр бэлтгээгүй		1		1	0.0							
4	“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ	ГСА-2022/01/СТА-ОНӨААН	Нийт 5 албан хаагчдад тэтгэмж, тусламж олгохдоо ХХОАТ суутгаагүй			155.0				155.0					
5	“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ	ГСА-2022/01/СТА-ОНӨААН	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчиж 13 ажилтанд 4,606.9 мянган төгрөгийн шагнал урамшуулал олгосон		1	2,689.3			1	2,689.3					
6	“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ	ГСА-2022/01/СТА-ОНӨААН	6 ажилтанд ээлжийн амралтын олговрыг цалин хөлстэй давхардуулан зөрүүтэй тооцож олгосон /403.8 мянга илүү, 58.1 мянга дутуу/		1	462.0			1	461.9					
7	“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ	ГСА-2022/01/СТА-ОНӨААН	Өмнөх онд барагдуулаагүй үлдсэн ААНБ, айл өрхөөс авах 18,117.0 мянган төгрөгийн хог хаягдлын авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулах		1	18,117.0					1	18,117.0			
ДҮН					6	47,965.6	3	26,542.3	2	3,306.2	1	18,117.0			
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал															

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1	“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ	ГСА-2022/01/СТА-ОНӨААН	Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш 13 худалдан авалт, 3 хөрөнгө зарцуулахтай холбоотой тушаал шийдвэр тус тус мэдээлээгүй		1	192,945.3					1	192,945.3				
ДҮН					1	192,945.3					1	192,945.3				
НИЙТ ДҮН					7	240,910.9	3	26,542.3	2	3,306.2	2	211,062.3				